

Огноо 2010.01.14
№10

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМ БАЙГУУЛНА

Х.ХАНГАЙ

Ирэх арваннэгдүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэхээр болжээ. Үүнтэй холбогдуулан "Хүний эрх хөгжил төв" болон "Глобинтернэшнл" төрийн бус байгууллага хамтран өнгөрөгч мягмар гаригт "Хүний эрхийн зөвлөлийн ээлжит дүгнэлт

хэлэлцүүлэгт төрийн бус байгууллагууд бэлтгэх нь" сэдэвт сургалт, зөвлөлгөөн зохион байгуулсан байна. Зөвлөлгөөнөөр Монгол Улс дахь хүний эрхийн жинхэнэ төлөв байдлыг олон улсын хэмжээнд гарган харуулж, хохирогчдын дуу хоолойг хэрхэн хүргэх, хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах тухай ярилцсан аж. Мөн Монголын хүний эрхийн төрийн бус байгууллагуудын

нэгдсэн форумыг зохион байгуулахаар тогтсон бөгөөд энэ асуудлаарх нэгтгэсэн илтгэлийг байгаль орчин, уул уурхай, хүнсний аюулгүй байдал, цөөнх болон шилжин суурьшигчдын хүний эрхийн байдал зэрэг асуудлаар бэлтгэхээр болжээ. Уг илтгэлийг бэлтгэхэд иргэний нийгмийн төлөөлөл, төрийн бус байгууллагуудыг татан оролцуулахыг Монгол Улсын Засгийн газарт уриалж буй аж.

+